



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

Сумдын ОНХСангийн батлагдсан төсвөөс нийтдээ 178.9 сая төгрөгийг аймгийн ОНХСанд төвлөрүүлж, төсвийн хуваарийг зөрчиж дутуу санхүүжүүлжээ.



АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Баян-Өлгий аймгийн аудитын газар Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган Аудитын менежер Х.Женисбек Ахлах шинжээч С.Салтанат Аудитор Х.Еркебулан 2017 оны 04 дүгээр сар Аудитын тайланг www.audit.mn вэб сайтаас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70423073, 70422954 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр, 104, 105, 217 тоот өрөө	Товчилсон үгийн тайлбар3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-6 Бүлэг 1. ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан талаар. • Төсвийн тодотголоор ОНХСангийн төсвийг 739.9 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар бууруулж баталсан байна.....7 • ОНХНСангаас 2016 онд 3260.1 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгаас 280.0 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна.....10 • Сумдын ОНХСангийн хөрөнгөөс жигд 12.0 хувиар хасаж, нийтдээ 178.9 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ОНХСанд төвлөрүүлж, батлагдсан төсвийн хуваарийг зөрчиж, сумдын ОНХСанг энэхүү хэмжээгээр дутуу санхүүжүүлжээ.....12 Бүлэг 2. ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн талаар. • ОНХСангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг баталсан ба санал авах үйл ажиллагаанд 5566 иргэн хамрагджээ.....15 • Сумдад нийтдээ 184.5 сая төгрөгийн өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээг иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй байхад батлан хэрэгжүүлжээ.....16 • ОНХСангаас 68.3 сая төгрөгийн хөрөнгийг 10 төсөл, арга хэмжээнд зориулалтын бус зарцуулжээ.....19 • ОНХСангийн хөрөнгөөр бий болсон 43.9 сая төгрөгийн хөрөнгийг байгууллагын данс, бүртгэл, орлогод авч, тайлан тэнцэлд тусгаагүй байна.....23 Бүлэг 3. ОНХСангийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан талаар. • ОНХСангийн зарцуулалтад тавих хяналтыг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаж, дүн шинжилгээ хийсэн байна.....26 • ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн байдлыг зааврын дагуу ил тод мэдээлж ирсэн байна.....27 • Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, биелэлтээ бүрэн тооцож ажилласан байна.....28 Дүгнэлт.....31 Зөвлөмж:32 Холбогдох байгууллагын санал.....33 Саналд өгсөн тайлбар.....
--	--

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЗЗНДТУТХ	Засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, ҮАГ-ын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилт, түүнд тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд нийцлийн аудит хийж, гарсан зөрчил, дутагдлыг арилгах, цаашид засаж сайжруулах санал, зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг хууль, журамд заасны дагуу төлөвлөж зарцуулсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад ОНХНС, ОНХСантай холбогдолтой аймаг, нийслэл, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, ЭЗТХ, Баг, хороодын Засаг дарга, ИНХ-ын шийдвэр, үйл ажиллагааг хамруулж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналын явц, санхүүгийн болон ажлын тайлан, холбогдох бусад бичиг баримтуудыг хамрууллаа.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орн нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлэх, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

2016 оны “Төсвийн тухай хууль”-д ОНХНСангаас ОНХСанд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 131.0 тэрбум төгрөгөөр баталсныг Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар 120.3 тэрбум төгрөг болгон бууруулж тодотгосон байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХСанд олгох шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг мөрдсөн байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж ирсэн байна.

Аймгийн ИТХурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн XVI дугаар хуралдааны 63 тоот тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн орлого буюу “Орон нутгийн хөгжлийн сан”-гаас олгох шилжүүлгийг 4018.0 сая төгрөгөөр баталсан байна.

2016 онд Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор ОНХСангийн санхүүжилт дутуу ирсэн ба УИХурлаас Төсвийн тухай хуулиар 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр ОНХНСангаас тус аймагт олгох шилжүүлгийг 3260.1 сая төгрөгөөр баталсан байна. Үүнтэй холбоотойгоор аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус II хуралдааны 08 тоот тогтоолоор аймгийн ОНХСангийн төсвийг 3278.1 сая төгрөгөөр тодотгож баталжээ.

Аймгийн ОНХСангийн дансанд 2016 оны эхэнд 127.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба улсын төвлөрсөн төсвөөс орлогын шилжүүлгээр 3260.1 сая төгрөгийн санхүүжилт авч, бусад орлогоос 152.6 сая төгрөгийн хөрөнгө төвлөрч, нийтдээ 3540.1 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна. Үүнээс 1442.0 сая төгрөгийг сумдын ОНХСанд, 1818.0 сая төгрөгийг аймгийн ОНХСанд хуваарилж, жилийн эцэст 430.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Эрсдлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны зарцуулалтад хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 400, 4000, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал, асуулга авах, харьцуулах, фото зургаар баримтжуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горимыг ашигласан болно.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Бүлэг 1

ОНХНСангаас 2016 онд 3260.1 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг авч, орон нутгаас 280.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж хуваарилсан байна.

Ерөнхий зүйл

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хуваарийн дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалтын байдалд 2 дугаар сарын 01-ний өдрөөс 4 дүгээр сарын 25-ныг хүртэлх хугацаанд нийцлийн аудит хийлээ.

Аудитыг ахлах шинжээч С.Салтанат ахалж, аудитор Х.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг хуваарийн дагуу өөрсдийн хуваарилагдсан төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд нийцлийн аудит хийж, ажлын тайланг бэлтгэв.

Нийцлийн аудитад аймгийн ОНХСан, 13 сум, 1 тосгоны ОНХСангийн 2016 оны үйл ажиллагааг бүрэн хамруулж, ОНХСангийн хөрөнгийн зарцуулалт, хууль, журмын хэрэгжилтэнд аудит хийлээ.

Аудитад Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол, Сангийн сайдын тушаалаар батлагдсан журмуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглаж, аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

Аудит хийх явцад аймгийн төвд болон 13 сум, 1 тосгонд хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг бүх сумдаар явж газар дээр нь шалгаж үзсэн бөгөөд шалгах явцад сумдын 30-50 иргэдээс санал асуулга авсан болно.

ОНХСангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан, орон нутагт хуваарилсан хөрөнгөөр олон нийтийн оролцоотойгоор сонгосон төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлж ирсэн байна.

1. ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан талаар.

Төсвийн тодотголоор Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг 739.9 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар бууруулж баталсан байна.

1.1. ОНХНС болон аймгийн ОНХСангаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн талаар.


1.1.1. Монгол Улсын Их Хурлаас баталсан 2016 оны “Төсвийн тухай хууль”-д ОНХНСангаас аймаг, нийслэлийн ОНХСанд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг

131.0 тэрбум төгрөгөөр баталжээ. Харин Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар 120.3 тэрбум төгрөг болгон тодотгож, анх баталсанаас 10.7 тэрбум төгрөгөөр бууруулан баталжээ.

Тус аймгийн ИТХурлын хуралдааны тогтоолоор ОНХНСангаас авах орлогын шилжүүлгийг 3278.1 сая төгрөгөөр баталсан нь анх батлагдсан хэмжээнээс 739.9 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар буурсан дүнтэй байна.

1.1.2. Аймгийн ИТХурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн XVI дугаар хуралдааны 63 тоот тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн орлого буюу “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”-гаас олгох шилжүүлгийн нийт дүнг 4018.0 сая төгрөгөөр баталжээ. Үүнээс сумдын ОНХСанд 2009.0 сая төгрөгийн, аймгийн ОНХСанд 2009.0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус хуваарилсан байна.

Үзүүлэлт	Анх баталсан төсөв	Тодотгосон төсөв /2016.10.07/
Орон нутгийн хөгжлийн сангийн нийт орлого	4018.0	3278.1
ОНХСангийн нийт зарлага	4018.0	3278.1
Үүнээс: Сумдын ОНХСанд олгох	2009.0	1639.0
Аймгийн ОНХСанд олгох	2009.0	1639.1




1.1.3. Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн II хуралдааны 08 тоот тогтоолоор аймгийн

ОНХСангийн төсвийг тодотгож ОНХНСангаас авах орлогын шилжүүлгийг 3278.1 сая төгрөгөөр баталж, аймгийн 2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс 127.4 сая төгрөгийг, бусад орлогоос 152.6 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, ОНХСангийн орлогын нийт дүнг 3558.1 сая төгрөгөөр баталжээ. Энэ нь анх батлагдсан төсвөөс 459.9 сая төгрөгөөр буюу 11.4 хувиар буурсан дүнтэй байна.

Үүнээс сумдын ОНХСанд 1726.6 сая төгрөгийн, аймгийн ОНХСанд 1831.5 сая төгрөгийн хөрөнгийг тус тус хуваарилжээ.

Үзүүлэлт	Тодотгосон төлөвлөгөө
ОНХНэгдсэн сангаас хуваарилах орлого	3278.1
Аймгийн 2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс хуваарилсан хөрөнгө	127.4
Аж ахуйн нэгж, байгууллагад олгосон санхүүжилтийг буцаан төлүүлсний орлого	152.6
Нийт дүн	3558.1
Үүнээс: Сумдын ОНХСанд олгох орлогын шилжүүлэг	1726.6
Аймгийн ОНХСанд олгох орлогын шилжүүлэг	1831.5



Төсвийн тухай хуулийн 59.2-т “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна”, Төсвийн тухай хуулийн 59.3-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жилд орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо орон нутгийн хөгжлийн индекс, тухайн сумын хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачлага зэрэг итгэлцүүрийг үндэслэн

тогтооно” гэсний дагуу тус аймгийн 13 сум, 1 тосгонд батлагдсан журмын дагуу хуваарилж, аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санг төлөвлөх ёстой.

Өөрөөр хэлбэл сумдын ОНХСангийн хөрөнгийг төлөвлөхдөө Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын дагуу Орон нутгийн хөгжлийн индекс-харгалзах хувийг 25 хувиар, Хүн амын тоо- харгалзах хувийг 25 хувиар, Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ- харгалзах хувийг 25 хувиар, Орон нутгийн татварын идэвх санаачлага- харгалзах хувийн жинг 25 хувиар хуваарилдаг журамтай байдаг.

1.2. Аймаг, сумын ОНХСангийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн талаар.

1.2.1. Аймаг, сумдын ОНХСангийн төсөвт уг сангийн орлогын эх үүсвэрүүдийг нарийвчилан тооцож, бүрдүүлэлтийг зохих журмын дагуу төлөвлөж тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.4, 22 дугаар зүйлийн 22.6.3, 27 дугаар зүйлийн 27.1.7 дахь заалтуудын шаардлагыг хэрэгжүүлээгүй ба өөрөөр хэлбэл ОНХСангийн орлогын шилжүүлгээс бусад эх үүсвэрийн бүрдүүлэлтийг нарийвчилан төлөвлөөгүй энэ талаар санаачлагатай ажиллаж чадаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 56.2-т заасны дагуу сумдын төсвийн үндсэн тэнцлийн ашиг гараагүй, 2016 онд орон нутгаас татварын хувь хэмжээг нэмэгдүүлэн төлөвлөж, нэмэгдэл эх үүсвэр бүрдүүлээгүй ба БНХАУ-лсаас 30.0 сая төгрөгийн хандив тусламж авсан ба төсвийн зарлагыг хэмнэх замаар бий болох эх үүсвэрийг бүрдүүлээгүй тул өөр нэмэгдэл эх үүсвэр бий болоогүй байна.

1.3. Аймгийн ОНХСангийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр нь бүрдүүлсэн талаар.

ОНХСангаас 2016 онд 3260.1 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгаас 280.0 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна.

1.3.1. Төсвийн тухай хуулийн 59.1-д “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ: 1. Импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 25 хувь; 2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь зэрэг орлогоос бүрдэнэ” гэж заасан байна.

2016 онд аймгийн орон нутгийн хөгжлийн санд ОНХСангаас 4018.0 сая төгрөгийн орлогын шилжүүлэг авахаар төлөвлөсөн боловч тодотголоор 3278.1 сая төгрөг болгож, 739.9 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар буурсан дүнтэй байна.


Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн II хуралдааны 08 тоот тогтоолоор аймгийн ОНХСангийн төсвийг тодотгож ОНХСангаас авах орлогын шилжүүлгийг 3278.1 сая төгрөгөөр баталж, аймгийн 2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс 127.4 сая төгрөгийг, бусад орлогоос 119.5 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, ОНХСангийн орлогын нийт дүнг 3558.1 сая төгрөгөөр баталжээ. Энэ нь анх батлагдсан төсвөөс 459.9 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар буурсан байна.

Үүнээс сумын ОНХСанд 1726.6 сая төгрөгийн, аймгийн ОНХСанд 1831.5 сая төгрөгийн хөрөнгө хуваарилсан байна.

/сая.төг/

Санхүүжилтийн эх үүсвэр	Тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл
ОНХСангийн 2015 оны жилийн эцсийн үлдэгдэл	127.4	127.4
Орлого		3412.7
ОНХНэгдсэн сангаас хуваарилагдсан хөрөнгө	3278.1	3260.1
2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс	9.9	9.9
ААНбайгууллагад илүү олгосон санхүүжилтийг буцаан төлүүлсний орлого	29.6	29.6
Цэнгэл сумын төсөлд эргэж төлөгдөх нөхцлөөр олгосон хөрөнгө	80.0	80.0
БНХАУлсын Алтай аймгаас олгосон хандив	30.0	30.0
Бусад	3.1	3.1
ОНХСангийн нийт эх үүсвэр	3558.1	3540.1
Сумын ОНХСанд хуваарилсан орлогын шилжүүлэг	1726.6	1280.1
Аймгийн ОНХСанд хуваарилсан орлогын шилжүүлэг	1831.5	1829.5
Эцсийн үлдэгдэл		430.0

ОНХСангийн хөрөнгийн 48.5 хувийг буюу 1726.6 сая төгрөгийг сумдын Орон нутгийн хөгжлийн санд, 51.5 хувийг буюу 1831.5 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжүүлэх санд хуваарилсан нь Төсвийн тухай хуулийн 59.2-д “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэсэн заалтыг зөрчсөн байна.



Гүйцэтгэлээр ОНХНСангаас 3260.1 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг авч, орон нутгийн 2015 оны төсвийн үлдэгдлээс 127.4 сая төгрөгийг, аж ахуйн нэгж, байгууллагад илүү олгосон санхүүжилтийг буцаан төлүүлсний орлогоос 29.6 сая төгрөгийг, Цэнгэл сумын ерөнхий төлөвлөгөөний зураг төсөвт эргэж төлөгдөх нөхцлөөр олгосон хөрөнгийг эргэж төлүүлсний орлогоос 80.0 сая төгрөгийг, БНХАУ-ын Алтай аймагаас 30.0 төгрөгийн хандивыг, Орон нутгийн төсвийн үлдэгдэл, бусад орлогоос 13.0 сая төгрөгийг тус тус төвлөрүүлж, нийт орлогын дүн 3540.1 сая төгрөг болсон байна. Улсын төсвөөс авахаар тооцсон орлогын шилжүүлгийн 3260.1 сая төгрөгийг авч, орлогын шилжүүлэг 18.0 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар дутуу санхүүжүүлсэн байна.

Дээрхи нийт орлогоос сумдын ОНХСанд 1280.1 сая төгрөгийг, аймгийн ОНХСанд 1829.5 сая төгрөгийг тус тус зарцуулж, жилийн эцэст аймгийн дүнгээр 430.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

1.3.2. Аймаг, сумдын ОНХСангийн төсөвт уг сангийн орлогын эх үүсвэрүүдийг нарийвчлан тооцож, бүрдүүлэлтийг зохих журмын дагуу төлөвлөж тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.4, 22 дугаар зүйлийн 22.6.3, 27 дугаар зүйлийн 27.1.7 дахь заалтуудын шаардлагыг хэрэгжүүлээгүй ба өөрөөр хэлбэл ОНХНСангийн орлогын шилжүүлгээс бусад эх үүсвэрийн бүрдүүлэлтийг нарийвчилан төлөвлөөгүй, энэ талаар санаачлагатай ажиллаж чадаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 56.2-т заасны дагуу сумдын төсвийн үндсэн тэнцлийн ашиг гараагүй, энэ талаар нэмэгдэл эх үүсвэр бий болоогүй байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2-т заасны дагуу импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн нэмэгдэл эх үүсвэр бий болгож, 2016 онд аймгийн ОНХСанд төвлөрүүлээгүй бөгөөд энэ талаар санаачлагатай ажиллаагүй байна.

Орон нутгийн төсвийн зардлыг хэмнэснээр бий болгосон эх үүсвэр гараагүй бөгөөд 2016 онд аймгийн ОНХСанд зардлыг хэмнэснээр хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

1.4. ОНХНСан болон аймгийн ОНХСангаас сумын ОНХСанд олгосон шилжүүлгийг хууль, журмын дагуу хуваарилж, батлагдсан хуваарийн дагуу олгосон талаар.

Сумдын ОНХСангийн хөрөнгөөс нийтдээ 178.9 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ОНХСанд төвлөрүүлж, батлагдсан төсвийн хуваарийг зөрчиж сумдын ОНХСанг дутуу санхүүжүүлжээ.

1.4.1. Аймгийн ИТХ-аас ОНХСангаас зарцуулах хөрөнгийн нийтдээ 3278.1 сая төгрөгөөр тодотгож баталсан бөгөөд ОНХСангийн хөрөнгийн 50 хувийг буюу 1639.0 сая төгрөгийг сумдын Орон нутгийн хөгжлийн санд, 50 хувийг буюу 1639.1 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжүүлэх санд хуваарилсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 59.2-д “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэсэн заалттай нийцэхгүй байна. ОНХСангийн төсөвт 2016 онд 1 удаа тодотгол хийгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг сумдад хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59.3-т заасан орон нутгийн хөгжлийн индекс, тухайн сумын хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачлага зэрэг итгэлцүүрийг үндэслэн тус аймгийн 13 сум, 1 тосгонд батлагдсан журмын дагуу хуваарилж, сумдын Орон нутгийн хөгжлийн санг бүрдүүлэх ёстой юм.

Өөрөөр хэлбэл сумдын ОНХСанд хөрөнгийг хуваарилахдаа Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын дагуу Орон нутгийн хөгжлийн индекс-харгалзах хувийг 25 хувиар, Хүн амын тоо- харгалзах хувийг 25 хувиар, Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ- харгалзах хувийг 25 хувиар, Орон нутгийн татварын идэвх санаачлага- харгалзах хувийн жинг 25 хувиар хуваарилдаг журамтай байдаг.

Гэтэл Сангийн яамнаас Санхүү, Төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнүүдэд өгсөн зөвлөмж ба өмнөх онуудад сумын ОНХСангийн хөрөнгийг хэт жижиг төсөл, арга хэмжээнд хуваарилж, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсан, сумдын хөгжлийн индексийг одоо хүртэл тооцож гаргаагүй зэрэг шалтгаануудыг харгалзан Сангийн яамнаас уг итгэлцүүрийн хувийг бусад үзүүлэлтүүдэд шилжүүлэн 33.3 хувиар тэнцүү хуваарилж, харгалзах үзүүлэлт тус бүрт ногдуулсан хөрөнгийг сумдын хувийн жингээр тооцож, Сангийн яамнаас өгсөн программд оруулан аймаг, сумын ОНХСанд хуваарилах хөрөнгийг 50:50 хувийн харьцаагаар хуваарилж, аймгийн ИТХуралдаанаар баталсан байна.

Хүн ам, нутаг дэвсгэр, алслалттай холбоотой тоо мэдээг статистикийн эмхтгэлээс, татварын идэвхийн сүүлийн 2 жилийн үзүүлэлтийг Татварын хэлтсээс гаргуулан авч сумын ОНХСанд олгох хөрөнгийг хуваарилахад ашиглажээ.

ОНХСангийн хөрөнгийн хуваарилалтыг хүснэгтээр үзүүлвэл

№	Сумдын нэр	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Санхүүжүүлсэн дүн	Зөрүү мөнгөн дүнгээр	Зөрүү хувиар
1	Алтай	134.6	109.8	96.6	13.2	12.0
2	Алтанцөгц	96.0	78.3	68.9	9.4	12.0
3	Баяннуур	125.6	102.5	90.2	12.3	12.0
4	Бугат	97.9	79.9	70.3	9.6	12.0
5	Булган	186.2	151.9	133.6	18.3	12.0
6	Буянт	107.7	87.9	77.3	10.6	12.0
7	Дэлүүн	176.1	143.7	126.4	17.3	12.0
8	Ногооннуур	156.9	128.0	112.7	15.3	12.0
9	Сагсай	121.3	99.0	87.1	11.9	12.0
10	Толбо	124.7	101.7	89.5	12.2	12.0
11	Улаанхус	162.6	132.7	116.8	15.9	12.0
12	Цэнгэл	174.7	142.5	125.4	17.1	12.0
13	Цагааннуур	74.6	60.9	53.6	7.3	12.0
14	Өлгий	270.1	220.3	193.7	26.6	12.0
	Дүн	2009.0	1639.0	1442.1	196.9	12.0
15	Аймгийн ОНХСан	2009.0	1639.1	1818.0	178.9	110.9
	Дүн	4018.0	3278.1	3260.1	18.0	0.5

Хүснэгтээс үзэхэд 2016 онд тус аймгийн ОНХСанд Улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг улсын төсвийн орлого тасарснаас шалтгаалж төлөвлөснөөс 757.9 сая төгрөгөөр буюу 18.9 хувиар дутуу санхүүжүүлсэн байна.

Харин тодотгосон төлөвлөгөөний дагуу ОНХНСангаас орлогын шилжүүлгээр олгох хөрөнгийг 50:50 хувиар хуваарилж баталсан боловч санхүүжилтийг олгохдоо сумдын ОНХСангийн хөрөнгөөс жигд 12.0 хувиар хасаж, нийтдээ 178.9 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ОНХСанд олгож, батлагдсан төсвийн хуваарийг зөрчиж, сумдын ОНХСанг энэхүү хэмжээгээр дутуу санхүүжүүлсэн зөрчил гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, мөн хуулийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Аудитын дүнгээр сумдын ОНХСангийн төсвөөс батлагдсан төсвийн хуваарийг зөрчиж аймгийн ОНХСанд төвлөрүүлсэн 178.9 сая төгрөгийг сумдад буцаан олгож, зөрчлийг арилгуулах, энэхүү зөрчлийг цаашид дахин давтан гаргахгүй байх талаар аймгийн Засаг даргад албан шаардлага өгсөн боловч албан шаардлагад гарын үсэг зурахаас татгалзаж, тайлбар ирүүлсэн болно.

Бүлэг 2

Санал авах үйл ажиллагаанд нийтдээ 5566 иргэн хамрагдаж, 112 төсөл, арга хэмжээг санал болгожээ.

2. ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх талаар.

ОНХСангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг баталсан ба санал авах үйл ажиллагаанд 5566 иргэн хамрагджээ.

2.1. ОНХСангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэсэн эсэх талаар.

2.1.1. Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын 2.3, 3.1.4-т заасны дагуу ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь орон нутгийн Засаг захиргааны байгууллагаас хөгжлийн талаар баримталж буй бодлого стратеги, төлөвлөгөө, аймгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан байх бөгөөд түүнийг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс хянаж, дүгнэлт гаргасан байх ёстой. Үүний дагуу Хөгжлийн бодлогын хэлтэс нь тус аймгийн 2010-2021 оны хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдсан эсэхийг бүх сумдад хянан шалгаж, нэгтгэж, дүгнэлт гаргаж тухайн үед холбогдох байгууллага, албан тушаалтанд тодорхой зөвлөмж өгсөн байна.

Ингэснээр ОНХСангийн төсөл, арга хэмжээний хөрөнгө нь байгаль орчныг хамгаалах, хотын өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн цэвэр, аюулгүй, тухтай орчинд амьдран аж төрөх нөхцлийг бүрдүүлэх, сургууль, эмнэлэг, нутгийн захиргааны байгууллагын ажлын байрны хэвийн ажиллагааг хангах, гэр хорооллын айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах зэрэг иргэдийн эрх ашигт нийцсэн бүтээн байгуулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Аймгийн ЗДТГазрын даргын шийдвэрээр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд иргэдээс санал авах, эрэмбэлэх, тэдгээрийг хэрэгжүүлэх, олон нийтэд танилцуулан хэлэлцүүлэх ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн даргаар Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, гишүүдээр Өлгий сумын ЗДТГазрын дарга, СТСангийн хэлтсийн мэргэжилтэн, ГХБХБГ-ын дарга, Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, аймгийн Барилгачдын холбооны тэргүүн, аймгийн ҮЭХолбооны тэргүүн нар орсон байна. Ажлын хэсэг аймгийн 2016 онд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан эсэхийг хэлэлцэн дүгнэлт гаргаж, урьдчилсан жагсаалтыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулан баталсан байна.

2.2 ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч, эрэмбэлсэн талаар.

Сумдад нийтдээ 184.5 сая төгрөгийн өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээг иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй байхад батлан хэрэгжүүлжээ.

2.2.1. Сумдын ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хийгдэхээр төлөвлөсөн ажил, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.5, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.2, 5.2-т заасны дагуу олон нийтийн оролцоог хангахын тулд тодорхой ажил зохион байгуулж ажилласан байна.


Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаар иргэдээс санал авах ажлыг 10 сум, 1 тосгонд иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулан саналын хуудсаар санал авчээ.

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн урьдчилсан жагсаалтыг гаргаж, аймгийн ЗДТГазрын веб хуудсанд тавьж цахим хэлбэрээр иргэд, байгууллагаас санал авснаас гадна иргэний танхимийн түвшинд Өлгий сумын төвийн багуудын иргэдийн оролцуулан хэлэлцүүлсэн байна. Цахим хэлбэрээр санал авахдаа иргэдээс гаргасан саналын хувийг харгалзан эрэмбэлж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцэж 2016 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг гаргаж, аймгийн ИТХурлын тогтоол гаргуулан батлуулсан байна.

Сумдын ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санал авах ажлыг нийт 56 багийн хэмжээнд зохион байгуулж, баг тус бүрээс гарсан саналыг эрэмбэлэн жагсаалт гаргаж, багийн иргэдэд танилцуулан багийн ИНХ-ын тэмдэглэлийг үндэслэн Багийн иргэдийн нийтийн хурлын тогтоол гаргажээ. Гэвч Сангийн сайдын 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5.2-т зааснаар санал авах ажлыг 2015 оны 5 дугаар сард багтаан явуулах ёстой байтал Ногооннуур, Баяннуур, Сагсай зэрэг сумууд 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар огт санал аваагүй байсан ба үүнийг ОНХСангийн хөрөнгийн санхүүжилт өмнөх оноос буурсан, өмнөх оноос шилжсэн төсөл, арга хэмжээний дутуу санхүүжилтийг олгох, өмнөх жилд санал асуулгад орж, тухайн жилд хэрэгжиж чадаагүй төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх үүднээс санал аваагүй гэсэн тайлбарыг өгч байсан.



2.2.2. 2016 оны ОНХСангийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санал авах үйл ажиллагаанд аймгийн дүнгээр 5566 иргэн оролцож сумдын нийт өрхийн 30.0 хувийг, аймгийн төвийн 9 өрх тутмаас 1 төлөөлөл хамруулсан нь ЗЗНДНТУТухай хуулийн 23 дугаар зүйлийн 10-д заасан “Баг, хорооны хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцох бөгөөд тухайн хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно” гэсэн заалтыг бүрэн хангасан байна.



2.2.3. Сумдын 2016 оны ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын талаар иргэдээс санал авах ажлыг хууль, тогтоомжид тавигдсан шаардлагын дагуу авч улмаар эрэмбэлж, төлөвлөгөөнд тусгах талаар анхаарч ажилласан байна. Сумдын иргэдээс авсан саналын дүнг нэгтгэж үзэхэд санал авах үйл ажиллагаанд аймгийн хэмжээгээр нийтдээ 5566 иргэн хамрагдаж, 226 төсөл, арга хэмжээ, ажлыг санал болгосон нь санал авах арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо өнгөрсөн оныхоос 40.2 хувиар буурсан дүнтэй байна. Аудитаар дараахь зөрчлүүд илэрсэн.Үүнд:

1. 2016 онд аймаг, сумын ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг судалж үзэхэд зарим сумд Багийн ИНХурлаас дэмжигдэж санал аваагүй, эрэмбэлсэн жагсаалтанд ороогүй төсөл, арга хэмжээг сумдын ИТХурлын хуралдаанаар баталж хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60.3.6 дахь заалтыг зөрчсөн байна.

Тухайлбал: Булган, Ногооннуур сум болон Цагааннуур тосгонд нийтдээ 184.5 сая төгрөгийн өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээг иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй байхад сумын ЗДТГазар болон Захирагчийн албаны саналаар эрэмбэд оруулж, сумын ИТХурлын хуралдаанаар хөрөнгө баталж, гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах замаар хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4-т “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.2-т “Тухайн орон нутгийн

иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цагааннуур тосгоны ОНХСангаас “Гудамжны гэрэлтүүлэг” төсөл арга хэмжээний талаар иргэдээс санал авч, төлөвлөгөөнд тусгагдсан боловч 2016 онд хэрэгжээгүй байхад 6.5 сая төгрөгийн хөрөнгийг, “Хүүхэд залуучуудын парк” төсөл, арга хэмжээний талаар иргэдийн саналыг авч эрэмбэлэгдээгүй, 2016 оны эхэнд төлөвлөгөөнд тусгагдаагүй, тухайн онд хэрэгжээгүй байхад 7.3 сая төгрөгийн бүгд 13,8 сая төгрөгийг жилийн эцэст гүйцэтгэгч “Өлгий Констракшн” ХХК-ны дансанд шилжүүлсэн байна. Иймд энэхүү 13,8 сая төгрөгийн хөрөнгийг Цагааннуур тосгоны ОНХСангийн данснд 2017 оны 3 дугаар сарын 01-ний дотор эргүүлэн оруулах арга хэмжээ авахыг албан шаардлагаар үүрэг болгов.

Аудитын дүнгээр энэхүү зөрчил, дутагдлуудыг дахин давтан гаргахгүй байх талаар Булган, Ногооннуур сумын Засаг дарга, Цагааннуур тосгоны захирагч нарт албан шаардлага өгсөн.

2.3. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан талаар.

2.3.1. 2016 онд тус аймгийн хэмжээнд хэрэгжих ёстой 226 төсөл, арга хэмжээнээс техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн нийтдээ 166 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

2016 онд аймгийн ОНХСангаар хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө эхлээд зураг төслийг нь урьдчилан гаргуулж, зарим шаардлагатай томоохон бүтээн байгуулалтын ажлын зураг төслийг нь тендер зарласны үндсэн дээр зураг төслийг нь гаргуулан экспертизээр батлуулан хэрэгжүүлсэн ба 2016 онд зураг төсөлгүй хэрэгжсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Сум, орон нутаг, багийн чанартай зам засах, урсгал засвар, тоног төхөөрөмж авах, сумдад интернет байгуулах зэрэг ажлуудыг зураг төсөвгүйгээр ажлын хэмжээ объектыг тогтоож, төсөл шалгаруулах замаар шууд гэрээгээр гүйцэтгүүлэхээр төлөвлөж баталсан байна. Өөрөөр хэлбэл өмнөх онуудад энэ талаар гарч байсан зөрчил, дутагдлуудыг арилгаж ажилласан байна.

2.4. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан талаар.

2015-2016 онд хэрэгжсэн буюу дараа онд хэрэгжихээр шилжсэн төсөл, арга хэмжээний нийтдээ 659.2 сая төгрөгийн санхүүжигдээгүй үлдэгдэлтэй гарсан байна.

2.4.1. Аймгийн хэмжээнд 2016 онд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжсэн нийтдээ 166 төсөл арга хэмжээний 6 төсөл, арга хэмжээний бараа ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 20 төсөл, арга хэмжээний бараа ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар, 140 төсөл, арга хэмжээний ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулах журмаар сонгон шалгаруулсан ба дээрхи төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтанд нийтдээ 164 аж ахуйн нэгж, иргэд оролцож худалдан авах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог зохих хэмжээгээр хангасан байна.

ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт



2016 онд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжих 9 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг Худалдан авах ажиллагааны албанаас, 144 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сумдын ЗДТГазрын дарга буюу захиалагчийн байгуулсан Үнэлгээний хороогоор шалгаруулжээ.

Тендер шалгаруулалтаар 105 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчээр аж ахуйн нэгж, компаниудыг, 59 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчээр иргэдийн бүлгүүдийг шалгаруулсан байна.

Харин аймгийн ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд Төв талбайн авто зогсоол, багийн эмч нарыг унаажуулах, Өлгий сумаас Цагааннуур чиглэлийн гарах замын гэрэлтүүлэг байгуулах, Өлгий сумын 4 дүгээр ахлах сургуулийн хөл бөмбөгийн талбай байгуулах, Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажилагааг цахимжуулах зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулинд заасны дагуу захиалагчаас тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хороог байгуулан ажиллуулж ирсэн ба уг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд аймаг болон сумдад ихэнхидээ худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн А-3 сертификаттай 1-2 хүнийг оруулан 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулж байгаа нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 47.4 дэхь заалтыг хангасан байна.

2.5. ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан талаар.

Орон нутгийн хөгжлийн сангаас 68.3 сая төгрөгийн хөрөнгийг 10 төсөл, арга хэмжээнд зориулалтын бус зарцуулжээ.

2.5.1. 2016 онд аймаг, сумын хэмжээнд ОНХСангийн хөрөнгөөр нийтдээ 226 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсанаас тухайн онд 166 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс 9 төсөл, арга хэмжээ дараа онд хэрэгжихээр шилжиж, 51 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. ОНХСангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан дараахь зөрчлүүд илэрчээ. Тухайлбал:

1. Сагсай, Улаанхус, Цэнгэл, Алтанцөгц, Ногооннуур зэрэг сумууд орон нутгийн иргэдийн саналыг авч эрэмбэлэгдээгүй байхад нийтдээ 68.3 сая төгрөгийн хөрөнгийг 10 төсөл, арга хэмжээнд зориулалтын бус зарцуулсан байна. Тухайлбал:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.3.4-т “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”-нд зарцуулахыг хориглоно, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.3-т “Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх”, мөн зааврын 4.5-д “орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул цаашид энэхүү зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

2016 онд аймгийн ОНХСангаас 1764.3 сая төгрөгийн хөрөнгийг 2014-2015 онд хэрэгжсэн 76 төсөл, арга хэмжээний санхүүжилтэнд зарцуулж, жилийн эцэст 407.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

2016 онд аймаг, сумдын ОНХСан нь одоогийн байдлаар 2014-2015 онд хэрэгжсэн буюу дараа онд шилжсэн төсөл, арга хэмжээний нийтдээ 407.2 сая төгрөгийн санхүүжилтийн өглөгтэй гарсан. Мөн 2016 онд хэрэгжсэн буюу дараа онд шилжсэн төсөл, арга хэмжээний 259.1 сая төгрөгийн дутуу санхүүжилттэй гарсан байна.

Өөрөөр хэлбэл 2014-2015 онд хэрэгжсэн буюу 2016 онд дараа онд хэрэгжихээр шилжсэн төсөл, арга хэмжээний нийтдээ 666.3 сая төгрөгийн санхүүжигдээгүй үлдэгдэлтэй гарчээ. 2014-2015 оны дутуу санхүүжилтийг 2016 оны ОНХСангийн төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны шилжих хөрөнгө оруулалт гэж баталсан боловч тухайн онд бүрэн санхүүжүүлж чадаагүй байна.

№	Аймаг, сумын нэр	Нийт орлогын дүн /сая.төг/	Үүнээс 2016 онд зарцуулсан дүн /сая.төг/	Өмнөх оны шилжих ХО, төсөл арга хэмжээнд олгосон санхүүжилт /сая.төг/	Зөрүү хувиар
1	Алтай	96.6	94.7	-	-
2	Алтанцөгц	69.9	59.1	27.4	46.4
3	Баяннуур	90.2	35.5	28.5	80.3
4	Бугат	85.1	84.6	82.4	97.4
5	Булган	160.9	120.6	19.2	15.9
6	Буянт	77.3	64.1	62.1	96.9
7	Дэлүүн	140.4	41.7	8.0	19.2
8	Ногооннуур	114.0	115.1	21.9	19.0
9	Сагсай	87.1	87.1	9.0	10.3
10	Толбо	93.3	74.6	18.1	24.3
11	Улаанхус	122.0	122.0	30.6	25.1
12	Цэнгэл	141.0	129.1	1.2	0.9
13	Цагааннуур	53.6	53.6	5.8	10.8
14	Өлгий	198.4	198.5	106.3	53.6
Дүн		1529.8	1280.3	420.5	32.8
15	Аймгийн ОНХСан	2010.3	1829.4	1343.8	73.5
	НИЙТ ДҮН	3540.1	3109.7	1764.3	56.7

Судалгаанаас үзэхэд 2016 онд Алтай сумаас бусад 12 сум, 1 тосгон, аймгийн ОНХСан нь нийтдээ 1764.3 сая төгрөгийн хөрөнгийг 2014-2015 оны шилжих ХО, төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнээс дүгнэлт хийж үзэхэд сумдууд

болон аймгийн ОНХСан нь зарцуулсан нийт хөрөнгийн 1.2-1343.8 сая төгрөгийг буюу 0.9-73.5 хувийг өмнөх оны шилжих ХО, төсөл, арга хэмжээний дутуу санхүүжилтэнд зарцуулсан тооцоо гарч байна.

Иймд өмнөх оны төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг 2017 оны ОНХСангийн хөрөнгөөс эхний ээлжинд санжүүжүүлж, дараагийн төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг аймаг, сумдын холбогдох албан тушаалтнуудад зөвлөсөн болно.

2.6. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгосон талаар.

2.6.1. 2016 онд аймгийн хэмжээнд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг болон үнэлгээний хорооноос гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж аймгийн ЗДТГазарт гэрээ байгуулах тухай зөвлөмж хүргүүлсэн байна. Үнэлгээний хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу ЗДТГазар гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Ажил гүйцэтгүүлэх гэрээг Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан тендерийн жишиг баримт бичигт заасны дагуу тендер шалгаруулалтын гэрээний маягтаар хууль журмын дагуу байгуулжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.2.2-т тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч нь Аймгийн ЗДТГазрын дарга, сумдад мөн хуулийн 45.6- д заасны дагуу сумдын ЗДТГазрын дарга нь захиалагч байна.

2016 онд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнүүдийн захиалагчийн хяналтыг ажлын нарийн төвөгтэй байдлыг харгалзан Барилга захиалагчийн албанд хуваарилан өгч, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж хавсралтаар хариуцуулан хяналтын ажлыг хийлгэсэн байна.

2016 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн байдалд аймгийн ЗДТГазрыг төлөөлж санхүүжилтийн акт болон талбайд хийж гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, хугацаа, чанарын талаар дээрхи байгууллага бүрэн хариуцаж гарын үсэг зурж байсан ба Хөгжлийн бодлогын хэлтсээс хяналтын хуудсаар давхар хяналт тавьж, гэрээний дагуу санхүүжилтийг олгосон байна.

2.6.2. 2016 онд сумдын ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын хувьд “барилга, байгууламж” гэсэн барилгын тухай хуулийн нэр томъёотой тохирч буй томоохон ажлуудад Барилгын захиалагчийн алба сумын Засаг дарга нартай харилцан тохиролцож гэрээ байгуулан мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Барилга угсралтын ажил буюу төсөл, арга хэмжээний ажил дууссан үед орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтан, Аймгийн ЗДТГазрын холбогдох мэргэжилтнүүд, Иргэний Нийгмийн байгууллага болох аймгийн ҮЭХолбоо, аймгийн иргэний танхим, Малчдын холбоо зэрэг байгууллагуудаар хөндлөнгийн хяналт,

мониторинг хийлгэн үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар авч хэлэлцсэн холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Аймгийн барилга захиалагчийн албанаас 2016 онд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжсэн нийтдээ 33 төрлийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, барилга угсралтын ажил буюу төсөл, арга хэмжээний ажил дууссан үед орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтан, Аймгийн ЗДТГазрын холбогдох мэргэжилтнүүд, иргэдийн төлөөллийг оролцуулан тухайн ажлыг комиссын акт бүрдүүлэн ашиглалтанд авч, холбогдох материалуудаа бүрдүүлсэн байна.

Сумдад ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад тухайн орон нутгийн ИТХурлын дэргэдэх хяналтын хороо, иргэд нийгмийн байгууллагууд төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1, 9.4-т заасны дагуу хяналт тавьж ажиллах ёстой боловч Алтанцөгц, Дэлүүн, Цэнгэл, Буянт сумууд жилд 1-2 удаа хяналт тавьж ажилласан бөгөөд бусад сумдад хяналт тавьж ажиллаагүй байна.

2.6.3. 2016 онд аливаа хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гэрээнд хэрэгжих төсөл, арга хэмжээний ажлын техникийн нөхцлийг хангуулах, гүйцэтгэж байгаа ажлын явц, гүйцэтгэлд нь мэргэжлийн зүгээс техникийн хяналт тавих, ажлын бодит гүйцэтгэлийг норм нормативын дагуу үнэн зөв тооцох талаар дурьдаж, мэргэжлийн байгууллагын хувьд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой тусгажээ. Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу ажил тус бүрт ажлын үе шатаар нь хяналтаа тодорхой түвшинд хэрэгжүүлж, гүйцэтгэгчээс гаргасан ажлын гүйцэтгэлийг тухай бүр хянаж баталсаны дагуу санхүүжилтийг олгож ирсэн байна.

Аливаа аж ахуйн нэгж, байгууллага тендерт шалгарч төсөл, арга хэмжээний ажлыг гүйцэтгэхээр болсон нөхцөлд Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.10-т заасны дагуу гүйцэтгэгчид урьдчилгаа олгохоор заасан бол захиалагч байгууллага гэрээний дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулан авч зохих журмын дагуу ажлын гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг олгож ирсэн байна. Гэвч аудитаар дараах зөрчил илэрчээ.

1. 2015 онд ОНХСангаас М.Икей баатарын хөшөөг сэргээн засварлах төсөл, арга хэмжээнд 9.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулахаар төлөвлөгөөнд тусгасан бөгөөд энэхүү төсөл, арга хэмжээ нь 2015-2016 онд дутуу буюу чанаргүй хэрэгжсэн байхад 4.5 сая төгрөгийн хөрөнгийг гүйцэтгэгч иргэн А.Мандатын дансанд шилжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, 41.2.3-т *“төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах”*, Сангийн Сайдын 2012 оны 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”-ын 4.2-т *“Захиалагч барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын, шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүрт нь арилгуулах арга хэмжээ авч ажиллах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд энэхүү хөшөөний засварын төсөл, арга хэмжээний ажлыг зураг, төсвийн дагуу 2017 оны 7 дугаар сарын 01-ний дотор бүрэн хийлгэж, холбогдох захиалагч байгууллагад хүлээлгэж өгөх талаар холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага өгсөн болно.



Толбо сумын Дотуур байрны дутуу хэрэгжсэн гадны хаалга



Өлгий сумын төв дэхь М.Икей баатарын хөшөөний засварын дутуу хэрэгжилт

2.7. ОНХСангийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бүртгэл тайланд тусгасан талаар.

ОНХСангийн хөрөнгөөр бий болсон 64,6 сая төгрөгийн хөрөнгийг байгууллагын данс, бүртгэл, орлогод авч, тайлан тэнцэлд тусгаагүй байна.

2.7.1. 2016 онд нийтдээ 166 төсөл, арга хэмжээ, хөтөлбөр хэрэгжсэнээс хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ажлыг ашиглалтад хүлээн авах комисс тухайн онд 135 хэрэгжсэн төсөл, арга хэмжээг ашиглалтанд хүлээж авсан ба 9 төсөл, арга хэмжээний санхүүжилт хүрэлцээгүй, хугацаанаас нь оройтож эхэлсэн зэрэг шалтгаанаар дараа онд хэрэгжихээр шилжсэн байна.



Өлгий сумын гүүрийн амны тохижилт



Улсын бүртгэлийн газрын цахимжуулалт



Өлгий сумын Иргэний танхимын тохижилт



Толбо сумын ЭМТөвийн шинжилгээний аппарат



Аймгийн СХЗХэлтсийн эталон тоног төхөөрөмж



Дэлүүн сумын Соёлын төвийн хөгжмийн зэмсэг

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд 22 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажил хэрэгжүүлснээс 21 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн хэрэгжүүлж, эрх бүхий комиссын актаар хүлээн авч, ашиглалтанд өгсөн байна

2.7.2. ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд бий болсон хөрөнгүүдийг тухайн байгууллагын данс бүртгэл, жилийн эцсийн тайлан тэнцэлд тусгасан эсэхийг шалгаж үзэхэд дараах зөрчил илэрчээ.

1. Улаанхус сум нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж бий болсон шилэн кабель, сумын вэб сайт зэрэг нийтдээ 19.4 сая төгрөгийн хөрөнгийг, Ногооннуур сум нь бөхийн дэвжээ, GPS, Цагдаагийн хашаа, худгийн засвар, мотоцикл зэрэг 24.5 сая төгрөгийн хөрөнгийг, Дэлүүн сум 20,7 сая төгрөгийн трансформаторыг ашиглалтанд хүлээж авсан боловч байгууллагын 2016 оны данс, бүртгэлд орлого авч, тайлан тэнцэлд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2.3-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6-д “ОНХС-ийн хөрөнгөөр

хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрхи хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу данс бүртгэлд орлого авч, 2017 оны эхний хагас жилийн тайлан тэнцэлд тусгуулах талаар тухайн сумдад албан шаардлага өгөв.

Аймаг, сумын ОНХСангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг тухайн байгууллагын данс, бүртгэл, тайлан тэнцэлд тусгах үйл ажиллагааг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч, сумдын Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн төлөөлөгч, ЗДТГазрын нягтлан бодогч нар хариуцан ажиллаж ирсэн ба аймгийн ОНХСангийн бүртгэлийг Сангийн яамнаас өгсөн программаар хөтөлж хагас, бүтэн жилээр санхүүгийн тайлан гаргаж, аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгүүлсэн байна.

Бүлэг 3

ОНХСангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан байна.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан талаар.

ОНХСангийн зарцуулалтад тавих хяналтыг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаж, дүн шинжилгээ хийсэн байна.

3.1. ИТХурлын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон аймгийн Дотоод аудитын алба ОНХСангийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажилласан талаар.

3.1.1. Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1, 9.2, -т заасны дагуу ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хяналт тавьж, хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэж байх ёстой юм.

Үүнийг газар дээр нь судалж үзэхэд 2016 онд Алтанцөгц, Дэлүүн, Цэнгэл сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, нийгмийн байгууллагаас ажлын хэсэг байгуулж ирсэн бол бусад аймгийн ИТХ, 10 сум, Цагааннуур тосгоны ИТХ-ын Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллага, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 онд ямар нэгэн хяналт, шалгалтын ажил огт хийгдээгүй байна.

Харин аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтэс, холбогдох мэргэжилтнүүд, Иргэний Нийгмийн байгууллага болох аймгийн ҮЭХолбоо, аймгийн иргэний танхим, Малчдын холбоо зэрэг байгууллагуудаар хөндлөнгийн хяналт, мониторинг хийлгэн үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар авч хэлэлцсэн байна.

3.2. ОНХСангийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу хүргүүлж, тайланд дүн шинжилгээ хийсэн талаар.

3.2.1. Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1-10.5-т заасны дагуу сумууд 2016 оны ОНХСангийн хэрэгжилтийн явцын хагас, бүтэн жилийн тайланг зааварт заасан хугацаанд аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлж ирсэн ба улмаар тус хэлтэс нь Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж ОНХСангийн хэрэгжилтийн үр дүнд дүн шинжилгээ хийж, сум тус бүрийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал, зөвлөмжийг

сум тус бүрээр гарган аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох арга хэмжээнүүдийг авч ажилласан байна.

Аймгийн ОНХСангийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гарсан зөвлөмжийн хамт заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлж байжээ

3.2.3. Аймаг, сумын Засаг дарга нар 2016 онд ОНХСангийн тайланг зохих заавар журмын дагуу гаргаж, хуулийн хугацаанд дээд шатны ТЕЗ-д хүргүүлсэн ба ОНХСангийн тайланг тухайн жилийн аймгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар сумдын ОНХСангийн 196,9 сая төгрөгийн санхүүжилтийн авлага, 287,7 сая төгрөгийн хэрэгжсэн ТАХ-ний ажлын гүйцэтгэлийн өглөгийг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй байсан зөрчлийг залруулга хийж арилгуулсан байна.

3.3 ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод мэдээлсэн талаар.

ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн байдлыг зааврын дагуу ил тод мэдээлж ирсэн байна.

3.3.1. Аймаг, сумын ЗДТГазраас Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын 5.1-д заасны дагуу 2016 онд хэрэгжүүлсэн, 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээ, ажлуудыг нэр төрөл, өртөг, зардлын дүнгээр Сангийн яамны “Pmmis.mof.gov.mn”, аймгийн “bayan-ulgii.gov.mn” вэб сайтад байршуулж, аймаг, сумдад мөн журмын 5.2, 5.3-т заасны дагуу орон нутгийн ЗДТГазрын байранд олон нийтэд харагдахаар самбарт байрлуулж, түүнд тухайн онд хэрэгжих төсөл, арга хэмжээ, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар фото зураг, тайлбарын хамт байршуулсан байна.

Аймаг, сумдад 2016 онд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээг “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын 5.2, 5.2, 5.3, 5.5-д заасны дагуу тухайн үед баяжуулж, хөрөнгийн зарцуулалтыг иргэд, олон нийтэд мэдээлж, олон нийтийн зүгээс тухайн төсөл, арга хэмжээний талаар тодорхой мэдээлэлтэй байх боломжоор бүрэн хангагдсан байна.

3.3.2. ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжиж ирсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийн мэдээллийг Сангийн яамны “mof.gov.mn” сайтад байршуулсан байдлыг шалгаж үзэхэд тус сайтад 13 сум, 1 тосгоны ОНХС-ийн цэс нээгдсэн байна.

Уг сайтад ОНХС-ийн сар бүрийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнийн дүнгээр болон хэрэгжих төсөл хөтөлбөрийн нэрээр оруулах ёстой боловч Сагсай, Бугат сумууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийн нэрээр байршуулах мэдээллийг огт байршуулаагүй, бүх сум ОНХС-ийн сарын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнийн дүнгээр нь мэдээлсэн байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийн нэрээр нь оруулах мэдээлэлд эрх зүй, тендерийн талаар, төлбөр тооцоо, зураг төсөв, гүйцэтгэл, хүлээж авсан акт, санал, гомдол зэрэг мэдээллүүдийг дэлгэрэнгүй байдлаар мэдээлэх ёстой юм.

Сумдын мэдээлэл тавьсан байдлаас үзэхэд 2, 3 дахь буюу тендер болон төлбөртэй холбоотой мэдээллүүдийг Сагсай, Бугатаас бусад сум байршуулж ирсэн ба бүх сум 1, 4, 5 дахь мэдээлэлийн хэсэгт огт мэдээлэл байршуулаагүй байна.

Өөрөөр хэлбэл тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр шалгарсан ААН-ийн нэр, гэрээний хугацаа, олгосон санхүүжилтийн хэмжээний талаар мэдээлэл байршуулсан боловч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дугаар, ажлын зураг төсөв, гүйцэтгэл, хэрэгжсэн арга хэмжээг хүлээж авсан акт, хэрэгжилттэй холбоотой гарсан санал гомдол зэрэг мэдээллүүдийг байршуулаагүй байна.

3.3.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2016 он болон 2017 эхний 3 сарын байдлаар ОНХСангийн худалдан авах ажиллагааг шилэн дансанд байршуулсан байдлыг шалгаж үзэхэд сумдууд 2016 онд хэрэгжүүлсэн, 2017 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг Сангийн яамны Pmmis. Mof.gov.mn, аймгийн ХАА-ны албаны meps.gov.mn сайтад тус тус байршуулсан байна.

Харин аймгийн ХАА-ны алба нь 2016 онд хэрэгжсэн, 2017 онд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг ХАА-ны газрын www.pmmis.mof.gov.mn, www.tender.bo.gov.mn, www.bayan-olgii.gov.mn, www.meps.gov.mn сайтуудад байршуулсан байна. 2017 онд хэрэгжихээр төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээний ажлыг байршуулан зарласан байна.

3.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль, тогтоомжтой нийцсэн талаар.

Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь одоохондоо бусад хууль тогтоомжийн заалт, агуулга тай бүрэн нийцэж байна.

3.5. Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн талаар.

Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, биелэлтийг тооцож ажилласан байна.

3.5.1. 2016 онд УАГазрын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийгдсэн нийцлийн аудитын үр дүнгээр 2 төрлийн актаар нийтдээ 2.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогдож, аймаг, сумдын ЗДТГазарт 431,5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 12 албан шаардлага, 6 заалт бүхий зөвлөмж өгөгдсөний дагуу аудитын дүнг аймаг, сумдын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тодорхой төлөвлөгөө гаргаж, ажил зохион байгуулж ажилласан ба акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тухайн онд багтаан аймгийн Аудитын газарт гаргаж ирүүлсэн байна.

Дээрхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд актын төлбөрийн 2.8 сая төгрөгийг 100 хувь барагдуулж, засаж залруулах, арилгаж ажиллах, дахин давтан гаргахгүй байх зорилгоор албан шаардлага өгөгдсөн 431.5 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгах талаар тодорхой ажил зохион байгуулсны үр дүнд энэхүү зөрчил, дутагдлуудыг хугацаанд нь бүрэн арилгаж, засаж залруулж үр дүнгээ өгсөн ба 6 төрлийн заалтаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтээ хугацаанд нь гаргаж өгсөн байна.

Дээрхи зөрчил, дутагдлуудыг арилгаж ажиллах талаар тодорхой ажил зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрч зөрчил, дутагдлын хэмжээ өмнөх оныхоос буураагүй байсан ба иргэдийн санал асуулгад ороогүй төсөл, арга хэмжээг эрэмбэд оруулж, төсөл, арга хэмжээнд хамруулж хэрэгжүүлсэн, зориулалтын бус зарцуулсан, үр өгөөж багатай төсөл, арга хэмжээнд зарцуулах, ОНХСангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг тухайн тухайн байгууллагын данс бүртгэлд орлого авч, тайлан тэнцэлд тусгаагүй байсан зөрчлүүд дахин давтагдан гарчээ.

3.6. Санал асуулгын талаар.

1.Тус Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны талаарх авах санал асуулгад 13 сум, нэг тосгоныг хамруулж санал асуулга авахад нийтдээ 426 иргэн оролцсон ба санал асуулгад оролцсон иргэдийг насны ангиллаар нь судалж үзэхэд 19-45 насны 276 иргэн, 45-60 насны 142 иргэн, 61-ээс дээш насны 8 иргэн байна. Боловсролын байдлаар ангилвал дээд боловсролтой 277, тусгай дунд боловсролтой 73, бүрэн дунд боловсролтой 76 иргэн санал асуулгад оролцсон.Хүйсээр нь ангилвал 255 эрэгтэй, 171 эмэгтэй иргэн санал асуулгад оролцжээ.

2. ОНХСангийн санхүүжилтээр ямар төсөл арга хэмжээ танай хороо, сум дүүрэгт хэрэгжиж буй талаар та хэр мэдээлэлтэй байна вэ? гэсэн асуултад 205 иргэн буюу санал асуулгад оролцсон иргэдийн 48.1 хувь нь санхүүжүүлж буй үйл ажиллагааны жагсаалт, хэрэгжилтийг сайн мэднэ гэж хариулсан бол 145 иргэн буюу 34.0 хувь нь ОНХСангаас төсөл арга хэмжээ санхүүжүүлдэг гэж сонссон, харин манай сумд ямар арга хэмжээ хэрэгжиж буйг мэдэхгүй гэсэн бол 76 иргэн буюу 17.9 хувь нь энэ талаар огт мэдээлэлгүй байна гэж хариулжээ.

Дээрхи хариултаас дүгнэлт хийж үзэхэд санал асуулгад оролцсон иргэдийн 51.9 хувь нь ОНХСангийн санхүүжилтээр тухайн баг, хороонд ямар төсөл, арга хэмжээ хэрэгжиж буй талаар мэдээлэлгүй байгаа нь тухайн баг, хорооны ИНХуралд оролцох иргэдийн оролцоо хангалтгүй, энэ талаар иргэдэд өгч буй мэдээлэл учир дутагдалтай байгааг харуулж байна.

3. ОНХСангийн асуудлыг хэлэлцэх баг хорооны ИНХуралд та оролцож байсан үү? гэсэн асуултад 151 иргэн буюу 35.4 хувь нь байнга оролцдог, 165 иргэн буюу 38.7 хувь нь хааяа оролцдог, 110 иргэн буюу 25.9 хувь нь огт оролцдоггүй гэж хариулжээ.

Санал асуулгад оролцсон иргэдийн 25.9 хувь нь баг хорооны ИНХуралд огт оролцож байгаагүй, 38.7 хувь нь хаяа оролцдог гэж хариулсан нь ОНХСангийн үйл ажиллагааны талаар иргэдийн мэдээлэл дутмаг байгаатай холбоотой ба нөгөө талаар иргэдийн өөрсдийн идэвхи, оролцоо сул байгаатай холбоотой. Энэ нь тухайн баг, хорооны зүгээс иргэдэд ОНХСангийн хөрөнгөөр тухайн онд хэрэгжих төсөл, арга хэмжээний талаар мэдээлэх, сурталчлах үйл ажиллагаа хангалтгүй зохион байгуулагдсаныг харуулж байна.

4.Хэрвээ оролцож байсан бол зайлшгүй шаардлагатай асуудлуудыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаар таны бодол? гэсэн асуултад санал асуулгад оролцсон иргэдийн 82 нь буюу 19.2 хувь нь цаанаасаа бэлтгэсэн асуудлуудын жагсаалтыг хэлэлцүүлж санал авдаг гэж хариулсан бол 167 иргэн буюу 39.2 хувь нь оролцогч иргэдээс санал авч дэвшүүлэн хэлэлцдэг, 89 иргэн буюу 20.9 хувь нь дээрхи хоёрын аль аль нь, 88 иргэн буюу 20.7 хувь нь иргэдийн саналыг сонсдоггүй, нэр төдий хурал болдог гэж хариулсан байна.

Энэ нь ОНХСангийн үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоо хангалтгүй байгааг харуулж байгаа бөгөөд иргэдийн саналыг сонсож, хүлээж авдаггүйгээс цаашид иргэдийн ИНХуралд оролцох оролцоо, идэвхи буурах хандлагатай байна.

5.ОНХСангийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон төсөл арга хэмжээний талаар мэдээллийг зарладаг үү? гэсэн асуултад санал асуулгад оролцсон иргэдээс 225 нь буюу 52.8 хувь нь тийм, 153 иргэн буюу 35.9 хувь нь зарладаг байх, гэхдээ би сонсоогүй, 48 иргэн буюу 11.3 хувь нь огт үгүй гэж хариулсан байна.

Санал асуулгад оролцсон иргэдийн 47.2 хувь нь огт зарлаагүй, би сонсоогүй гэж хариулсан нь ОНХСангийн үйл ажиллагааны талаар мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлдэггүйтэй холбоотой гэж үзэх үндэслэлтэй юм.

6.ОНХСангаас ямар төсөл арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас танай өрхөд ирж байсан үү? гэсэн асуултад иргэдийн 32.9 хувь нь буюу 140 иргэн саналын хуудас, мэдээлэл байнга ирдэг, 150 иргэн буюу 35.2 хувь нь саналын хуудас ирдэггүй ч хурал болох талаар мэдээлэл өгдөг, 136 иргэн буюу 31.9 хувь нь саналын хуудас ирдэггүй, мэдээлэл огт өгдөггүй гэж хариулжээ. 31.9 хувь нь саналын хуудас ирдэггүй, мэдээлэл огт өгдөггүй гэсэн нь Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 06-ны 43 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5.3-т заасан “Баг, хорооны Засаг дарга Нийтийн хурлын зарыг хурал болохоос 2 долоо хоногийн өмнө тухайн баг, хорооны айл өрх бүрт хүргэж, зар хүлээн авсан гарын үсгийг айл өрх бүрээс авч баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

7.ОНХСангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтад иргэд хяналт тавих бололцоо, механизм байгаа юү? гэсэн асуултанд 44.8 хувь нь буюу 191 иргэн бүрэн боломжтой, 91 иргэн буюу 21.4 хувь нь боломжгүй, 33.8 хувь нь буюу 144 иргэн энэ талаар мэдэхгүй байна гэж хариулсан байна. Олонхи нь хяналт тавих боломжгүй мэдэхгүй гэж хариулсан нь тухайн баг, хороонд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаар мэдээлэлгүй байгааг харуулж байна.

Нийцлийн аудитын дүнгээр нийтдээ 505.3 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 9 сумын ОНХСанд 317,4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 8 албан шаардлага, Аймгийн ОНХСанд 187.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага тус тус өгч, аймгийн Засаг даргад 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлэв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, нийцлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

ОНХСангийн талаар:

1. Төсвийн тодотголоор ОНХСангийн төсвийг 739.9 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар бууруулж баталсан байна.
2. ОНХНСангаас нийтдээ 3260.1 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгаас 280.0 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрүүлсэн байна.
3. Сумдын ОНХСангийн төсвөөс нийтдээ 178.9 сая төгрөгийн хөрөнгийг батлагдсан төсвийн хуваарийг зөрчиж аймгийн ОНХСанд төвлөрүүлж, дутуу санхүүжүүлжээ.
4. ОНХСангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг баталсан ба санал авах үйл ажиллагаанд 5566 иргэн хамрагджээ.
5. Сумдад нийтдээ 184.5 сая төгрөгийн өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээг иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй байхад батлан хэрэгжүүлжээ.
6. ОНХСангаас 68.3 сая төгрөгийн хөрөнгийг 10 төсөл, арга хэмжээнд зориулалтын бус зарцуулжээ.
7. ОНХСангаас 2 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байхад 13.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
8. ОНХСангийн хөрөнгөөр бий болсон 64.6 сая төгрөгийн хөрөнгийг байгууллагын данс бүртгэл, орлогод авч, тайлан тэнцэлд тусгаагүй байна.
9. ОНХСангийн зарцуулалтад тавих хяналтыг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаж, дүн шинжилгээ хийжээ.
10. ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилт, гүйцэтгэлийг ил тод мэдээлсэн байна.
11. Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, биелэлтийг тооцож ажилласан байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн засаг дарга А.Гылымхан-д:

1. ОНХСангийн хөрөнгөөс зориулалт бус төсөл, арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан, иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлсэн байдалд дүгнэлт хийж, цаашид энэхүү зөрчлийг арилгуулах, ОНХСангийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах.

Холбогдох байгууллагын санал



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-37-62

2017.04.28 № 8-03/847

танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцав.

Цаашид нийцлийн аудитын тайланд дүгнэлт хийж, тайланд тусгасан зөвлөмжийг зөрчилгүй ажиллахад мөрдлөгө болгон ажиллах болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

З.БОЛАТ



ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М. ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

С.САЛТАНАТ

АУДИТОР

Х.ЕРКЕБУЛАН